



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 138

Арвайхээр

Хамтарсан багийг шинэчлэн
байгуулах тухай

“Хүүхдийн эрхийн тухай” хуулийн 7.1, “Хүүхэд хамгааллын тухай” хуулийн 10.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/328 дугаар тушаалаар батлагдсан “Хамтарсан багийн ажиллах журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн эрхийг хангах, хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлэх, хүүхэд хамгааллын ажлыг сайжруулах зорилгоор сумын хүүхэд хамгааллын “Хамтарсан баг”-ийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, баг бүрт ажиллах “Хамтарсан баг”-ийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн байгуулсугай.

2. Багийн хамтарсан багийн бүрэлдэхүүнийг байгуулж, удирдлага зохион байгуулалт, арга зүйн зөвлөмжөөр хангаж, үйл ажиллагааг тасралтгүй, тогтвортой, үр дүнтэй хэрэгжих нөхцлийг бүрдүүлэн, үйл ажиллагааны үр дүнг хагас, бүтэн жилээр сумын “Хамтарсан баг”-д тайлагнаж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/328 дугаар тушаалаар батлагдсан “Хамтарсан багийн ажиллах журам”-ыг мөрдлөг болгож ажиллахыг сум, багийн “Хамтарсан баг”-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

4. Сумын, багийн “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хяналт тавьж ажиллахыг сумын ЗДТГазрын Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн /Н.Мөнгөнцэцэг/-д үүрэг болгосугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2013 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн “Хүүхэд хамгааллын баг байгуулах тухай” а/143 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ



14 0075

Сумын Засаг даргын 2017 оны . 04
дүгээр /дугаар/ сарын . 04 ны /ний/ өдрийн
01 . дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт
138



СУМЫН ХАМТАРСАН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч: Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан
мэргэжилтэн

Багийн гишүүд: Багийн Засаг дарга нар

Сум хариуцсан Нийгмийн ажилтан

Сум хариуцсан Иргэний бүртгэлийн ажилтан

Багуудын хэсгийн Төлөөлөгч нар

ӨЭМТөвийн ахлагч эмч нар

Багийн Нийгмийн ажилтнууд

ЕБСургуулийн Нийгмийн ажилтнууд

Сумын Засаг даргын 2017 оны . 04 /
дүгээр /дугаар/ сарын . 04 /
дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



БАГИЙН ХАМТАРСАН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч: Багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Багийн Нийгмийн ажилтан

Багийн гишүүд: Багийн ИНХурлын дарга

Багийн хэсгийн Төлөөлөгч

Харьяалах багийн ӨЭМТөвийн эмч

Харьяалах багийн ЕБСургуулийн Нийгмийн ажилтан

Багийн цагдаа

Олон нийтийн цагдаа